



**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
МЕНЕЖМЕНТ ҮЦК ХХК**

**2020 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН II ДҮГЭЭР ХУРАЛ

2020



АГУУЛГА



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



ХОЁРДУГААР БҮЛЭГ
ХЭЛТСҮҮДИЙН 2020 ОНЫ ТАЙЛАН



ГУРАВДУГААР БҮЛЭГ
ХЭЛТСҮҮДИЙН 2020 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС
ЖИЛИЙН ТАЙЛАН



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ТӨСӨЛ, ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ХҮРЭЭНД
ХИЙСЭН АЖИЛ





КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

БҮТЭЦ, ОРОН ТОО

“Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, Менежмент ҮЦК” ХХК-ийн бүтэц, зохион байгуулалт



ХОМК



ТУЗ-ийн баталсан бүтэц, зохион байгуулалтын хүрээнд 25 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.



КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

ТУЗ-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/ 2020 онд удаа хуралдаж, тулгамдсан асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлэж ирсэн.

ТУЗ-ийн дарга



Ц. Түмэнцогт

”Эрдэнэс-Оюутолгой” ХК-ийн
Гүйцэтгэх Захирал



С. Амарсайхан

Улсын Их Хурлын
гишүүн



Г. Түвдэндорж

Сангийн Яам Төсвийн
Хөрөнгө Оруулалтын
Газрын Дарга

ТУЗ-ийн гишүүд



Г. Өлзийсайхан

Гадаад Харилцааны
Яам, Гадаад Худалдаа
Эдийн Засгийн Хамтын
Ажиллагааны газрын
Дэд Захирал



Р. Дагва

Нийслэлийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын
Дарга



Ч. Энхбат

Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүн



Д. Бадрал

Голомт банк Байгууллагын
банкны Газрын Захирал



Ч. Ганхуяг

Улаанбаатар Хотын
Худалдааны Танхимын
Ерөнхийлөгч



Б. Түвшин

Нийслэлийн Иргэдийн
Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгч



КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

1. 2020.01.15. Нийслэлийн хөгжлийн сан, Нийслэлийн ногоон сангуудын зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авав.
2. 2020.01.17. Голомт Кастодиан банкттай хөрөнгө хадгалах гэрээ байгуулав.
3. 2020.01.28. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, Хөрөнгө хадгалах гэрээ хийгдэв.
4. 2020.03.15. AmCham холбооны гишүүн байгууллага болов.
5. 2020.04.01. СБД-ийн татварын хэлтэст татвар төлөгчөөр бүртгүүлэв.
6. 2020.04.10. МҮЦАЭХ-ны хөрөнгийн зах зээлийн эрх олгох сургалтад нийт ажилчдаараа хамрагдаж сертификат авав.
7. 2020.04.13. Нэгж эрх эзэмшигчдийн хурлын 06/11, 06/12 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын сангуудын дүрэм бодлогын баримт бичгийг шинэчлэн батлагдсан.
8. 2020.04.13. ТУЗ-ын хурлаар компанийн бүтцийг шинэчилж, бизнес төлөвлөгөө батлуулав.
9. 2020.05.10. НИТХ-ын шийдвэрээр компанийн дүрмийн санг 4.5 тэрбум ₮ - өөр нэмэгдүүлэв.
10. 2020.05.21. Туул, Сэлбэ, Дунд голын эргийн тохижилтын ажлын хэсэг байгуулах тухай НЗДТГ-ын А/61 дүгээр тушаал гарав.
11. 2020.05.25. Туул, Сэлбэ, Дунд голын төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх төслийн тухай НИТХ-ын Тэргүүлэгчдийн 91 дүгээр тогтоол гарав.
12. 2020.05.29. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх эрхийг НӨУБХОМ ҮЦК ХХК-д НЗД-ын А/768 дугаар захирамжаар үүрэг болгов.
13. 2020.06.15. Тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар ГБМЗХ 2020/27-034 дуусгав.
14. 2020.07.08. Сангийн хөгжүүлэлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Мөнхтуяа нь “Монгол улсын сангийн яамны Жуух бичиг”-ээр, Үйл ажиллагааны хэлтсийн ахлах нягтлан бодогч Б.Нэмжбадгар нь “Санхүү-банкны тэргүүний ажилтан” цол тэмдэгтээр тус тус шагнагдав.
15. 2020.08.10. 2018/03/16 – ны өдөр гарсан тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар Хан-уул дүүргийн 4, 5, 6, 7, 8-р хороо, 80 га газрын захиалагчийг өөрчлөх хүсэлт хүргүүлэв.
16. 2020.09.25. Хөрөнгө оруулалтын хэлтсийн Дарга Б.Баттулга нь МҮЦАЭХ-ны бүх гишүүдийн “ИХ ХУРАЛ”-аар Хяналтын зөвлөлийн даргаар сонгогдов
17. 2020.11.03. Компанийн Гүйцэтгэх захирал Ө.Мөнхдаваа нь МҮЦАЭХ-ны Удирдах зөвлөлийн дэргэдэх Сахилгын хорооны даргаар сонгогдож ажиллаж эхлэв.




КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

БОЛОВСОН ХҮЧИН


ТУЗ-ийн баталсан бүтэц, зохион байгуулалтын хүрээнд 25 хүний орон тоотой ажилласан.

МУЦАЭХ-ны “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэшлийн эрх олгох, аттестатчилах” сургалтад ажилтнуудын хамрагдсан байдал




Хөрөнгө оруулалтын мэргэжлийн боловсон хүчин

- Сангийн менежер 2
- Төслийн мэргэжилтэн 1
- Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн 1
- Санхүүгийн шинжээч 1
- Эрсдэлийн мэргэжилтэн 1




2020 онд зохион байгуулагдсан сургалтын тоо


- Ажлын байранд дээр зохион байгуулагдсан сургалт 13
- Тэнхимээр зохион байгуулагдсан сургалт 5
- Нийт сургалтын тоо 18



Ажилчдын нас, хүйсний харьцаа



Ажилчдын боловсролын байдал





КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

КОМПАНИЙН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА



МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО /MASD/

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн оролцогч талуудтай хамтран ажиллах тэднээс туршлага судлах, нийслэлийн бүтээн байгуулалтын хүрээнд хөрөнгө оруулалт татах чиглэлээр МУЦАЭХ-ны гишүүн болсон. Тус холбооны бүх гишүүдийн “ИХ ХУРАЛ”-аар компанийн гүйцэтгэх захирал Ө.Мөнхдаваа нь Удирдах зөвлөлийн дэргэдэх сахилгын хорооны дарга, ХОХ-ын дарга Б.Баттулга нь Хяналтын зөвлөлийн даргаар тус тус сонгогдож ажиллаж байна.



Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрлэлийн тэнхим /Mongolian national chamber of commerce and industry/

Дотоодын бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах, нийслэлийн тулгамдсан асуудалд оновчтой шийдэл олохоор төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулахын хүрээнд МҮХАҮТ-ын гишүүнээр элссэн. Түүнчлэн танхимийн дэргэдэх Бизнес эмэгтэйчүүдийн зөвлөлтэй уулзалт хийж төсөл хөтөлбөрт хамтран ажиллах боломжийн талаар судлаад байна.



Монгол дахь Америкийн Худалдааны Танхим /AMCHAM/

Бид компанийнхаа эрхэм зорилго болон алсын харааны хүрээн дэх тодорхой зорилгуудыг хэрэгжүүлэхээр АНУ-аас хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх, хөрөнгө оруулалт менежментийн чиглэлээр туршлага судлах олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах зорилгоор тус байгууллагын гишүүн болж АНУ-д зохион байгуулагдсан “Хөрөнгө оруулалтын чуулга” уулзалтад амжилттай оролцоод байгаа билээ.



КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

КОМПАНИЙН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА



Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл инновацын газар

Нийслэл хотын эдийн засгийн бүтцийг сайжруулах, үйлдвэрлэл, инновацийг хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн орчин нөхцөлд гарч болох өөрчлөлт, шинэчлэлт, шийдлийг ашиглан нийслэлийн өмнө тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх талаарх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэн концесс хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулж хөгжүүлэхэд хамтын үйл ажиллагааны зорилго чиглэгдэж байна.

Стартап маркетинг спэйс /SMS/, START

Стартап энтрепнершип чиг хандлагыг олон нийтэд таниулах, дэлгэрүүлэх зорилгоор дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж Стартап компаниудад зориулсан эко орчин бүрдүүлэхээр зорин ажиллаж байна. Цаашид хоёр сангийн хөрөнгө оруулалтын чиглэлд тохирч байгаа төслүүдийн санал авах талаар хамтран ажиллахаар болсон.

Каритас Чех Репаблик Монгол

Ногоон сангийн хөрөнгө оруулалтын чиглэлийн хүрээнд байгууллагын хэрэгжүүлсэн “Барилгын гаралтай хог хаягдлыг дахин боловсруулах” хөтөлбөрт оролцож Барилгын гаралтай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн төсөлд хөрөнгө оруулахаар судлагдсан байна. Цаашид хамтын ажиллагааны хүрээнд “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах төсөл”-д хамтран оролцохоор болсон.

Гүнд инвестмэнт ХХК

Хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хамтарсан хөрөнгө оруулалт хийх болон бусад чиглэлээр хамтран ажиллахаар болсон. Туршлага судлах болон хамтарсан хөрөнгө оруулах хийх замаар мөн өөрсдийн бойжуулж буй төслүүдтэй хамтран ажиллах хамтарч ажиллахаар болоод байна.



КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

КОМПАНИЙН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Гадаад харилцааг тэлэх чиглэлээр



01

Нью-Йорк хотын Wallstreet-д байрлах хөрөнгийн бирж болон хөрөнгө оруулалтын менежментийн чиглэлээр ажилладаг хуулийн фирмийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судлав.

MOU Дээрх уулзалтуудын хүрээнд гаднын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх, мэргэжлийн зөвлөгөө авах, тэдгээрээс туршлага хуримтлуулах, хууль эрх зүйн хүрээнд хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.

Asian Fund forum international , Asia 2020 арга хэмжээ

02



Дэлхийн хөрөнгө оруулалтын чиг хандлагыг тодорхойлох, олон улсын 1500 гаруй нөлөө бүхий шийдвэр гаргагч, шинийг санаачлагч, хөрөнгө оруулагчдыг цуглуулдаг дэлхийн хамгийн том Сангуудын арга хэмжээнд цар тахал гарсантайгаар цахим хэлбэрээр бүхий л уулзалтад оролцож холбоо харилцаагаа тогтоосон.

03

Connect Forum Online 2020 – accelerating the future of funds:



Calastone байгууллага нь өөрсдийн техник, технологийн шийдлээ танилцуулан зах зээл дээрх оролцогч талуудыг уулзуулах зорилготой зохион байгуулагдсан. Энэхүү арга хэмжээнд манай байгууллага өөрсдийгөө танилцуулан цаашид хамтран ажиллах боломжтой байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох зорилготой оролцсон.

Азийн үнэт цаасны зах зээлийн 25 удаагийн форум

04



Азийн үнэт цаасны форум нь жил бүр өөр өөр сонгогдсон улс орнуудад зохион байгуулагддаг. Азийн зохицуулах байгууллагууд болон тэдгээрийн чиг хандлагыг тодорхойлдог арга хэмжээ юм. Бид энэхүү арга хэмжээнд оролцон Азийн улс орнуудын хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг судлахаас гадна манай байгууллагын хувьд санхүүжилт татаж болохуйц ногоон эдийн засгийг дэмжсэн санхүү, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүдийг олон улсын зах зээлд гаргах боломжийн талаар туршлага судалсан.



ХЭЛТСҮҮДИЙН 2020 ОНЫ ТАЙЛАН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ТАЙЛАН

Компанийн ТУЗ-ийн 2020 оны 04 сарын 13-ний өдрийн 06/07 дугаар тогтоолоор бүтэц зохион байгуулалтын шинэчлэн өөрчлөгдөж Хөрөнгө оруулалтын хэлтэс болон өөрчлөгдөн дарга-1, мэргэжилтэн-3 нийт 4 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

“Нийслэлийн хөгжлийн сан” “Нийслэлийн ногоон сан” болон нийслэл хотын хөгжлийн бодлогод нийцсэн төслүүдээс байгаль орчны болон нийгмийн үр өгөөжтэй төслүүдэд анхан шатны судалгаа, нарийвчилсан үнэлгээнүүдийг хийж төсөл хөтөлбөрүүдийг танилцуулах, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад дүгнэлт оруулах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын боломжуудыг судлах, хөрөнгө оруулагчтай харилцах, хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулалтын орчны судалгаа, төслийн бааз бэлтгэх зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

“Нийслэлийн хөгжлийн сан”, “Нийслэлийн ногоон сан”-ийн хүрээнд 2020 оны 6 сарын 01-ээс 2020 оны 11 сар хүртэл нийт 18 хөрөнгө оруулалт хүссэн хүсэлт хүлээн авч анхан шатны судалгаа хийсэн.

“Нийслэлийн хөгжлийн сан”- с хөрөнгө оруулалт авах чиглэлээр нийт 15 төсөл ирсэн Үүнд:
-Дэд бүтэц болон бүтээн байгуулалтын салбар /12 төсөл/
-Барилгын салбар /3 төсөл/

“Нийслэлийн ногоон сан”-д хөрөнгө оруулалт авах чиглэлээр нийт 3 төсөл
-Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр /3 төсөл/

Нийслэлийн ногоон сан” Хувийн ХОС ТЗК ХХК, “Нийслэлийн хөгжлийн сан” Хувийн ХОС ТЗК ХХК үүсгэн байгуулсан бөгөөд Татварын хэлтэст татвар төлөгч хуулийн этгээдээр бүртгүүлж татвар төлөгчийн гэрчилгээ, тоон гарын үсэг авсан

Засгийн газрын 2021-2025 оны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн засаг даргын 2021-2025 оны хөгжлийн үндсэн чиглэлийн хүрээнд Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2020 онд хөгжүүлэх чиглэлд компаниас хэрэгжүүлэх ажлын санал, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/ -г хэрэгжүүлэх ажлын саналыг НЗДТГ-т боловсруулж өгсөн.

“НӨУБХОМ ҮЦК” ХХК-тай Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулж, Голомт Кастодиан банктай Хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан болно.

Төр хувийн хэвшлийн түншлэлээр Нийслэлд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх журмын дагуу Туул, Сэлбэ голын эргийн тохижилтын төсөл хамтран хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт ажиллаж амжилттай зохион байгуулсан.

“Нийслэлийн Ногоон Сан” “Нийслэлийн Хөгжлийн Сан” -гийн үйл ажиллагааны 13 багц журам батлагдаж СЗХ-д хүргүүлсэн

Хөрөнгө оруулалтын сангуудын 2, 3 дугаар улирлын санхүү, татварын тайланг хууль, журмын дагуу хугацаа алдалгүй тайлагнасан. “Нийслэлийн Ногоон Сан” “Нийслэлийн Хөгжлийн Сан” -гийн үйл ажиллагааны 13 багц журам батлагдаж СЗХ-д хүргүүлсэн

Хөрөнгө оруулалтын сангуудын 2, 3 дугаар улирлын санхүү, татварын тайланг хууль, журмын дагуу хугацаа алдалгүй тайлагнасан.

Хос Зөгий ХХК-аар вебсайтыг бүрэн автомат хийлгэсэн.

Компанийн ТУЗ-ийн 2020 оны 04 сарын 13-ний өдрийн 06/07 дугаар тогтоолоор бүтэц зохион байгуулалтын шинэчлэн өөрчлөгдөж Сан Хөгжүүлэлтийн Хэлтэс болон өөрчлөгдөж дарга, сангийн мэргэжилтэн, мэргэжилтэн 4 ажилтантай ажиллаж байна.


САНГИЙН ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ХЭЛТСИЙН ТАЙЛАН



ХЭЛТСҮҮДИЙН 2020 ОНЫ ТАЙЛАН

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТАЙЛАН

Компанийн ТУЗ-ийн 2020 оны 04 сарын 13-ний өдрийн 06/07 дугаар тогтоолоор бүтэц зохион байгуулалтын шинэчлэн өөрчлөгдөж Эрсдэлийн удирдлагын хэлтэс болон өөрчлөгдөн дарга-1, мэргэжилтэн-2 нийт 3 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.



- Хөдөлмөрийн дотоод журмын шинэчлэн боловсуулалт хийж ажилласан.
- Албан тушаалын тодорхойлолтын шинэчлэн боловсруулалт хийгдсэн.
- Компанийн www.ubim.mn вэбсайтыг тогтмол ажиллуулж эхэлсэн.
- Info@ubim.mn домайн хаягийг ажилтан бүрт нээж, өдөр бүр албан хэрэгцээнд ашиглаж байна.
- Компанийн удирдлагын дэмжлэгтэйгээр нийт ажилтнуудын 95% нь Хөрөнгө оруулалтын тусгай эрхийн үнэмлэх авсан. Цаашид хөрөнгийн зах зээлд ажиллах бүрэн боломжтой
- Компанийн сайн засаглал, Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, олон улсын жишиг, Авилгын эсрэг хамтдаа зэрэг сургалт, нөлөөллийн ажлуудыг амжилттай зохион байгуулсан.
- Нийт боловсон хүчний 65% нь 2-оос дээш гадаад болон дотоодын их сургуулийг дүүргэсэн
- Бүх ажилтнуудын 75% нь 21-35 насны удирдлага, мэргэжилтнүүд ажилладаг.

Үйл ажиллагааны Хэлтэс нь дарга бөгөөд менежер, нягтлан бодогч, хүний нөөцийн мэргэжилтэн-бичиг хэрэг, хуульч, дотоод ажилтан- нярав гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ТАЙЛАН



КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТОВЧ ТАЙЛАН

НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.05.07-ны өдрийн №72 тоот тогтоолоор 5 тэрбумын дүрмийн сантай үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

2019 оны Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 9/36 дугаар тогтоолоор дүрмийн санд 4,5 тэрбум төгрөг баталсан.

Одоо нийт 9,5 тэрбумын дүрмийн сантай үйл ажиллагаа явуулж байна.

2020 оны санхүүгийн үйл ажиллагаа

- “Нийслэлийн Хөгжлийн Сан”-ийн дүрмийн санд 2 тэрбум
- “Нийслэлийн Ногоон Сан”-ийн дүрмийн санд 100 сая тус тус хөрөнгө оруулалт хийсэн.

Үлдэгдэл 7 тэрбум 4 сая төгрөг нь

- Голомт банкны 8115102096 дансанд 4 тэрбум
- Голомт банкны 8115102097 дансанд 1 тэрбум
- Голомт банкны 8115102098 дансанд 1,7 тэрбум төгрөг
- Үйл ажиллагааны зардалд 700 сая төгрөг зарцуулагдсан байна.


“НӨУБХОМ ҮЦК” ХХК-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 19-ны дугаар 05/03 тогтоолоор 2020 оны үйл ажиллагааны төсөв батлагдсан.

Тус компаний 2020 оны 09 дугаар сарын 30-ний байдлаар нийт 9,1 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, үүний 9,06 тэрбум буюу 99,6%-ийг эргэлтийн хөрөнгө, 66,3 сая төгрөг буюу 0,4%-ийг эргэлтийн бус хөрөнгө эзлэж байна. Эх үүсвэрийн 0,2% ийг өр төлбөр, 99,8%-ийг өөрийн хөрөнгө эзлэж байна.

2020 оны 3-р улиралаар нийт 236,9 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны болон хадгаламжийн хүүний орлого олж, 707,2 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, /-470,1/ сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.



2020 ОНЫ ХЭЛТСҮҮДИЙН СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН





ХЭЛТСҮҮДИЙН 2020 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

ЗОРИЛТ 1-ИЙН ХҮРЭЭНД

ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖИЛ	ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ХАРИУЦСАН ХЭЛТЭС
Санхүүгийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой ханган ажиллах	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэвийн үйл ажиллагааг тогтмол ханган ажиллах	Үйл ажиллагааны хэлтэс
Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг ханган ажиллах	Албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу зохион байгуулах, хөтлөх, бүрдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах, хяналт тавьж ажилласан.	Үйл ажиллагааны хэлтэс
Хүний нөөцийн үйл ажиллагааг ханган ажиллах	Компанийн хүний нөөцийн үйл ажиллагааг хэвийн явуулах, ажилчдыг идэвхжүүлэх, ажиллах таатай орчинг бүрдүүлж ажилласан.	Хөрөнгө оруулалтын хэлтэс Сангийн хөгжлийн хэлтэс
	Хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх, санхүү хөрөнгө оруулалтын чиглэлээр болон бусад сургалтад холбогдох мэргэжилтнүүд хамрагдсан.	Эрсдэлийн удирдлагын хэлтэс Үйл ажиллагааны хэлтэс
Дотоод үйл ажиллагааг хэвийн, тогтвортой байлгах	Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг тогтмол хэвийн явуулах нөхцөлийг ханган ажилласан.	Үйл ажиллагааны хэлтэс

ЗОРИЛТ 2-ИЙН ХҮРЭЭНД

ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖИЛ	ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ХАРИУЦСАН ХЭЛТЭС
Хөрөнгө оруулалт хийх, хамтран ажиллах	Туул голын эргийн тохижилтыг ТХХТ-ийн журмын дагуу оролцогчийг сонгон шалгаруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.	Хөрөнгө оруулалтын хэлтэс Сангийн хөгжлийн хэлтэс
	Төсөлд хөрөнгө оруулалт хийхээр компанид төслүүдийг судалж эрсдэлийн зөвлөлөөр хэлэлцэж, хөрөнгө оруулалтын зөвлөлөөр хэлэлцүүлж, ТУЗ-аар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Хөрөнгийн зах зээлд арилжаа хийхээр судалж байна.	Хөрөнгө оруулагч болон Санхүүгийн зохицуулах хороо бусад хуулийн этгээдэд шаардлагатай мэдээ тайланг цаг тухай бүрт нь тайлагнаж ажилласан.
Сангийн хяналт тайлагнал	Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны эрсдэлийг хянаж ажилласан.	Хөрөнгө оруулалтын хэлтэс Сангийн хөгжлийн хэлтэс Эрсдэлийн удирдлагын хэлтэс Үйл ажиллагааны хэлтэс
	Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ХХК-ны 2021 он хүртэлх баримтлах стратеги төлөвлөгөө боловсруулсан.	Улаанбаатар хотод хэрэгжих "Угсармал орон сууцны барилгуудын дулаан алдагдлыг бууруулах төсөл"-д хөрөнгө оруулалтын менежментийн компаниар хамтран ажиллахаар зорьсон боловч Ковид 19 нөхцөл байдлаас тус ажил хойшлогдсон.
Сангийн хөгжүүлэлт хийх	Төсөл хөтөлбөрт мэргэжлийн хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжүүлэх ажлын хүрээнд	Хөрөнгө оруулалтын хэлтэс Сангийн хөгжлийн хэлтэс
	REIT Санг үүсгэн байгуулах судалгааны ажил хийгдсэн.	



ХЭЛТСҮҮДИЙН 2020 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

ЗОРИЛТ 3-ИЙН ХҮРЭЭНД

ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖИЛ	ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ХАРИУЦСАН ХЭЛТЭС
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны журам болон тогтолцоог сайжруулах	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны журам, бодлого, бусад баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж батлуулан батлуулж мөрдөж ажиллаж байна.	Хөрөнгө оруулалтын хэлтэс
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой Монголын болон Олон улсын хууль тогтоомж, шинэ мэдээ, үнэлгээний аргачлал болон бусад судалгааг тогтмол хийж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан.	
Төсөл хөтөлбөр хүлээн авч үнэлэх, дүгнэх	Хөрөнгө оруулалт хийх төслийн танилцуулга бэлэн болсон байна. 8-9-р саруудад төлөвлөгөөний 35% биелэлт, 10-12-р саруудад төлөвлөгөөний 85% биелэлттэй байна.	
Гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээг тэлэх	Хөрөнгө оруулалтын сангууд тус бүр шинэ төсөл хүлээн авах нэг, нэг сувагтай болно International fund forum, Asia fund forum-д цахим хэлбэрээр тус тус оролцсон.	Хөрөнгө оруулалтын хэлтэс Сангийн хөгжүүлэлтийн хэлтэс
Судалгаа шинжилгээ хийх	Хөгжлийн сангийн Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн хүрээнд нийт активын 20% хүртэлх 12 санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах боломжтой. Үүний хүрээнд МХБ дээр бүртгэлтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ХК-ууд, хаалттай/ нээлттэй бондуудад судалгаа хийсэн.	
	REIT сан байгуулах ажлын хэсэг гарч судалгаа хийж дууссан.	
Нийслэлээс өгсөн шууд үүрэг даалгаврыг биелүүлэх	Тохижилтын ажлын хэсэгт орж ажиллан, сонгон шалгаруулалтын баримт бичиг боловсруулалт, холбогдолтой бусад үүрэг даалгаврыг биелүүлж ажилласан.	

ЗОРИЛТ 4-ИЙН ХҮРЭЭНД

ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖИЛ	ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ХАРИУЦСАН ХЭЛТЭС
Баримт бичгийг холбогдох хууль тогтоомж болон компанийн үйл ажиллагаатай уялдуулан шинэчлэх, мэдээлэл солилцох	Холбогдох журмуудад шинэчлэл өөрчлөлт хийж боловсруулан батлуулан мөрдөж ажиллаж байна. Албан тушаалын тодорхойлолтыг бүтэц өөрчлөгдсөний дагуу шинээр боловсруулсан болон журмуудын хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.	Эрсдэлийн удирдлагын хэлтэс
	Удирдах дээд байгууллага болон холбогдох хэлтсээс ирүүлсэн санал болон батлагдсан удирдамжийн дагуу хяналт эрсдэлийн үнэлгээг хийж зөвлөж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажилласан.	
Компанийн хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох	Төслийн эрсдэлийн дүгнэлт гарган эрсдэлийн зөвлөлд танилцуулан Хөрөнгө оруулалтын зөвлөлд оруулахаар ажиллаж байна.	
	Хөрөнгө оруулалтын сангуудын эрсдэлийн удирдлагын журмын хэрэгжилтийг хангуулж ажилласан.	
	Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд учирч болох эрсдэл тодорхойлон хамгаалалтын багц үүсгэн ажиллаж байна.	



ТӨСӨЛ, ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРТЭЙ ХОЛБООТОЙ ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

Сан үүсгэн байгуулсан зорилго

- Монгол улсын хөгжлийн тогтвортой үзэл баримтлал Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн зорилго тавин ажиллаж байна.
- Нийслэлийн агаар орчны бохирдлыг бууруулах, байгаль хамгаалах
- Цэвэр технологийг дэмжин ногоон эдийн засгийг хөгжүүлэх
- Урт хугацаандаа ядуурлыг бууруулах дунд болон урт хугацааны төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулах

“Нийслэлийн Хөгжлийн сан”, “Нийслэлийн Ногоон сан”-уудыг байгуулан ажиллалаа.

Төслийн мэдээлэл тоогоор



Төслийг сонгон шалгаруулах үйл явц

Нарийвчилсан үнэлгээ хийсэн төслүүд

№	Хөрөнгө оруулалт хүссэн компанийн нэр	Төслийн нэр	Хүссэн хөрөнгө оруулалтын хэмжээ
1	“Сайн цаас” ХХК	“Цаас дахин боловсруулах үйлдвэрийн төсөл”	1 тэрбум төгрөг
2	“Газком” ХХК	“Хийн шийдэл төсөл”	4 тэрбум төгрөг
3	“Тэнгэр-Уул трейд” ХХК	“Барилгын гаралтай хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн төсөл”	960 сая төгрөг
4	“Монгол алтайн цаг” ХХК	“Их гэр төсөл”	380 сая төгрөг
5	“Мон арболит” ХХК	“Модон блок үйлдвэрлэх үйлдвэрийн төсөл”	145 сая төгрөг

АНХАН ШАТНЫ МАТЕРИАЛ	Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн этгэд байх; Чанаргүй зээлийн үлдэгдэлгүй бөгөөд зээлийн сайн түүхтэй байх; Залилан мэхлэх зэрэг зөрчил гаргаагүй байх;
АНХАН ШАТНЫ СУДАЛГАА	Тухайн төслийг төслийн менежер хариуцан авч төслийн бүртгэл хөтлөх; Анхны шатны уулзалтуудыг хийх; Төсөлтэй холбоотой судалгаа хийж, нэмэлт материал авах; Төслийн танилцуулга бэлдэн шууд удирдлагад танилцуулах;
НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ШААРДЛАГА	Нийцтэй байх; Тодорхой байх; Үндэслэлтэй байх; Бодитой байх; Төсөл хэрэгжүүлэгчийн туршлага хангалттай байх;
НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ	Төсөл санаачлагч болон хэрэгжүүлэгч байгууллагаас ирүүлсэн материалуудтай танилцах; Газар дээрх уулзалтыг хийж, бүтээгдэхүүн болон үйлдвэртэй танилцах; Холбогдох хууль эрх зүйн зохицуулалт, баримт бичигтэй нийцэж байгаа эсэхэд хяналт тавих; Төслийг үнэлгээний моделээр үнэлэх; Хөрөнгө оруулалтын болон санхүүгийн шинжилгээ хийж төслийн хөрөнгө оруулалтын хувилбаруудыг бэлдэх; Төслийн үнэлгээний дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах; Төслийн эрсдэлийн үнэлгээ хийх; Эрсдэл, аудитын дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах; Төслийн танилцуулга бэлдэх;

Нийт холбогдсон төслүүдийн салбараар нь харуулвал

Хөгжлийн сан	Бүтээн байгуулалт	8
	Барилга	6
	Авто тээвэр	5
	Дэд бүтэц	15
Ногоон сан	Орчны бохирдол бууруулах	15
Нийт		49



ТӨСӨЛ, ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ


ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ

Туул, Сэлбэ голын эргийн тохижилт

Туул, Сэлбэ голын эргийн дагуу иргэд, олон нийтийн тав тухт; амарч зугаалах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл бүрдүүлэх зорилгоор тус орчмын газарт эрүүл мэнд, соёл, амралтын цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж бий болгох төслийг “Төр, хувийн хэвшлийн түншлэл”-ээр хэрэгжүүлнэ. Нийслэлийн харьяа газар, хэрэгжүүлэгч агентлагуудаас хуули хүрээнд хамтран ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.



Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба




НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ӨРӨНХӨЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗАР



Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар




Нийслэлийн Байгаль орчны газар



Тогтоол, захирамж

2020 оны 05 дугаар сарын 25-ны өдөр НИТХ-ын тэргүүлэгчдийн 91 дүгээр тогтоолыг үндэслэн 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Нийслэлийн Засаг Даргын А/768 захирамжаар Туул, Сэлбэ, Дунд голын эргийн тохижилтын төслийг “Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Нийслэлд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх журам”-ын дагуу зохион байгуулж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхийг Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-д үүрэг болгосон.

Тогтоол, захирамж





ТӨСӨЛ, ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ



Туул голын эргийн тохижилт төслийн ерөнхий төлөвлөлт



Нийт хөрөнгө оруулалт:



Өөрийн хөрөнгө:



Зээлийн задаргаа:

ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТЫН ЗАДАРГАА




ТӨСӨЛ, ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ

80 га талбай нь дараах байдлаар төлөвлөгдсөн



7.46 га талбайд 9 төрлийн 19 ширхэг спортын талбай бүхий цогцолбор



34.7 га талбай нь “Гэр бүлийн бүс”

Туул голын эргийн тохижилтыг нийт талбайн хэмжээ 114.7 га бүхий 2 хэсэг газар байх бөгөөд дараах байдлаар төлөвлөлт хийсэн.



Цэцэрлэгийн насны хүүхдийн тоглоомын талбай – 2ш


Сургуулийн насны хүүхдийн тоглоомын талбай



Мах шарах хэсэг – 2ш



Усан боомт





ТӨСӨЛ, ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ

Сэлбэ голын эргийн тохижилт төслийн ерөнхий төлөвлөлт



БАЙГАЛЬ ОРЧИН

- Ажлын байр бий болох,
- Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх,
- Спортын талбай – нийгмийн эрүүл мэндийг сайжруулах.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө Оруулалт хийх,
- Хөрөнгө оруулалтын өгөөж хүртэх,
- Нийгэм, эдийн засгийн эерэг үр дүн авчрах.



НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ

- Сэлбэ голын эргийн бохирдлыг бууруулах,
- Сэлбэ голын эргийг хамгаалах, урсацыг сайжруулах,
- Цэцэрлэгт хүрээлэнгээр УБ хотын тоосжилтыг бууруулах.

01

Төслийн байршил:

Сүхбаатар дүүргийн 1, 7, 8-р хороо, Баянзүрх дүүргийн 1, 6, 25-р хороо

02

Нийт талбайн хэмжээ:

Сэлбэ голын эргийн тохижилт нийт 2.6 км урттай 18га газар

14%

Хөрөнгө оруулалтын дотоод өгөөж

(IRR):



8,104,754.7
мян. Төг

Нийт хөрөнгө оруулалт (CAPEX):



ТӨСЛИЙН ҮР
ШГИЙН ТӨСӨӨЛ



20 жил

Төсөл хэрэгжүүлэх хугацаа:

8.76 жил

Хөрөнгө оруулалт нөхөх хугацаа

(PB period):



ТӨСӨЛ, ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ



Төсөл хэрэгжсэнээр хүртэх үр ашиг

Сэлбэ голын эко орчныг сэргээж, голын усыг бохирдлоос хамгаална.

Элс, шороо голд урсан орохоос хамгаална, хагшаас хуримтлалыг багасгаж

Усны чанар болон орчныг сэргээн сайжруулна.

Цэцэрлэгт хүрээлэнгээр УБ хотын тоосжилтыг бууруулах

ТХХТ-ийн хүрээнд хэрэгжиж хөрөнгө оруулалт, арчилгааг нь төсөвт дарамт учруулахгүйгээр тогтвортой удаан хугацаанд авч хянах

Төслийн хугацаанд ний 271610900 төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг улсын төсөвт төвлөрүүлнэ.

Хотын лэл бүтэц хөгжинэ.

Төсөл хэрэгжиснээр нийт 45 байнгын ажлын байр (15 шууд, 30 шууд бус) шинээр бий болно.

Хүүхэд залуус эрүүл чийрэг өсөх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчныг бий болгоно.

Хотын хүн амын эрүүл мэндийг сайжруулан, амьдрах орчны чанарыг дээшлүүлнэ.



ТӨСӨЛ, ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ

Налайх олон улсын ачаа тээврийн парк

НИТХ-ын тэргүүлэгчдийн “Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төв”, “Налайх олон улсын ачаа тээврийн парк” байгуулах тухай 81 дүгээр тогтоолыг үндэслэн “Төсөл хэрэгжүүлэх тухай” 2020 оны А/1124 дугаар Нийслэлийн засаг даргын захирамжаар “Налайх олон улсын ачаа тээврийн парк” байгуулах төслийг “Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Нийслэлд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх журам”-ын дагуу зохион байгуулж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхийг “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК-д үүрэг болгосон.



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

Улаанбаатар хотод бууж байгаа бүр төрлийн ачаа, барилгын материал, тээврийн хэрэгсэл, хориотой бараа, хими уул уурхай шатах тослох материал, шингэрүүлсэн хий зэрэг бүх төрлийн ачааг олон улсын стандартын дагуу ангилан ачиж буулгах төмөр замын зам талбай, орчин үеийн төхөөрөмжөөр тоноглогдсон нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх логистикийн төвийг Улаанбаатар зүүн хэсэгт Налайх дүүрэгт байгуулах, улмаар бүс нутгийн ачаа тээврийн сүлжээнд хамрагдах зорилготой.






ТӨСӨЛ, ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ

GOALS

Нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудал

Улаанбаатар хотын өнөөгийн дэд бүтцийн тогтолцооны сөрөг үр дагавар бол хот дундуур явдаг төмөр замын тээвэр, олон тооны гарам, барилгын болон бөөний захууд, ачилт буулгалтын талбай, химийн, аюултай ачааны терминал, түгжрэл, ачааны машинуудын угаар, тоос, бохирдол зэргээс үүсэх аюул занал нь нийслэлийн оршин суугчдын амар тайван, аюулгүй орчинг зөрчиж байна. Төслийг хэрэгжүүлснээр эдгээр асуудлуудыг шийдвэрлэх том алхам болж чадна.



01

Монгол Улсын УИХ, Засгийн Газрын 2020 -2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт:

Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.

02

Улаанбаатар хотыг 2030 он хүртэлх мастер төлөвлөгөөнд:

Налайх хотыг үйлдвэр, суурьшлын бүс, мөн худалдаа логистикийн зангилаа хот болгох талаар тусгажээ.

03

Хуурай боомтын тухай засгийн газар хоорондын хэлэлцээрт:

Хуурай боомтыг байгуулж, ажиллуулахад мөрдөх үндсэн зарчмын дагуу “налайх олон улсын ачаа тээврийн парк” байгуулах төслийг хэрэгжүүлнэ. төсөл хамтран хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах сонгон шалгаруулалтын баримт бичгийг бэлтгэсэн.

04

“Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Нийслэлд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх журам”-ын дагуу зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг зарлан, төсөл хамтран хэрэгжүүлэх хувийн хэвшлийг сонгон шалгаруулах юм.



ХЭЛТСҮҮДИЙН 2020 ОНЫ ТАЙЛАН

ДОТООД ХЯНАЛТЫН АЛБАНЫ ТАЙЛАН

Дотоод хяналтын алба нь Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК-ийн ТУЗ-ийн баталсан бүтэц, зохион байгуулалтын хүрээнд 3 хүний (Ахлах хянан шалгагч, аудитор-1, Хянан шалгагч-2) орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

2020 оны 1-12 сард компанид хүргүүлсэн зөвлөмж, биелэлт


№	ОГНОО	ШАЛГАЛТ ХИЙСЭН НЭГЖ	ШАЛГАЛТЫН АГУУЛГА
1	2019.12.30	“НӨУБХОМ ҮЦК”-ийн нийт ажилтнуудад	Компанийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, ажилтнуудын 2019 оны ажлын бүтээмж
2	2020.01.28	ХУБХГ газар	2 дугаар сарын ажлын төлөвлөгөөнд
3	2020.01.30	“НӨУБХОМ ҮЦК”-ийн нийт ажилтнуудад	2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад өгсөн зөвлөмж
4	2020.04.02	Хөрөнгө оруулалт, бодлого хэрэгжилтийн газар	Нийслэлийн хөгжлийн сан ХОС, Нийслэлийн ногоон сан ХОС-ийн Үйл ажиллагаа, ажлын явц, Ирүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн шалгаруулалтын үйл явц, Боловсруулсан дүрэм журам нь холбогдох хууль, дүрэм, журамтай нийцэлд
5	2020.06.25	Үйл ажиллагааны хэлтэс	Компанийн ТУЗ-ийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ний өдрийн 06/07 дугаар тогтоолоор бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотой Албан тушаалын тодорхойлолт боловсруулах
6	2020.06.26	Сангийн хөгжүүлэлтийн хэлтэс	2020.04.02-нд хүргүүлсэн зөвлөмжийн дагуу хийгдсэн ажлуудын хэрэгжилтэд
7	2020.06.26	Хөрөнгө оруулалтын хэлтэс	2020.05.25-ны өдрийн Сангийн шалгалтын тайлангийн хурлаар өгсөн зөвлөмж дагуу хийгдсэн ажлын хэрэгжилтэд
8	2020.06.26	Үйл ажиллагааны хэлтэс	Компанийн үйл ажиллагааны хэлтсийн үйл ажиллагаа, ажлын явцад; Хүний нөөцийн үйл ажиллагаа, ажлын явцад
9	2020.08.14	Үйл ажиллагааны хэлтэс	Компанийн 2020 хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт
10		Үйл ажиллагааны хэлтэс	2020 оны хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн шинжилгээ
11	2020.08.31	Эрсдэлийн удирдлагын хэлтэс	ЭУХ-ийн үйл ажиллагааны явцад мониторинг хийх

2020 онд компани дээр 11 шалгалт хийж компанийн бүх ажилчид болон 4 хэлтэст нийт 121 зөвлөмж хүргүүлж ажилласан. Зөвлөмжийн биелэлт 96% байна.

Шалгалт, зөвлөмж, дүгнэлт



Компанид хүргүүлсэн зөвлөмж



ДХА-ны товч тайлан

Дотоод хяналтын алба	Тайлант хугацаанд Дотоод хяналтын албаны дүрэм, журам боловсруулан аудитын хороогоор батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.
Төлөвлөгөөт ажлынхаа зэрэгцээ	Эрсдэлийн удирдлагын хэлтэс, Хөрөнгө оруулалтын хэлтэс, Сан хөгжүүлэлтийн хэлтсүүдийг хариуцан хэлтсийн дарга болон ажилтнуудын ажлыг удирдан чиглүүлж, зөвлөгөө өгч
Сургалт	МҮЦАЭХ-ны “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх” сургалтад хамрагдсан. Засгийн газрын Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтад хамрагдсан. Компанийн бүх ажилчдыг хамарсан сургалтуудад хамрагдсан.




ТӨСӨЛ, ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ

GOALS

Нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудал

Улаанбаатар хотын өнөөгийн дэд бүтцийн тогтолцооны сөрөг үр дагавар бол хот дундуур явдаг төмөр замын тээвэр, олон тооны гарам, барилгын болон бөөний захууд, ачилт буулгалтын талбай, химийн, аюултай ачааны терминал, түгжрэл, ачааны машинуудын угаар, тоос, бохирдол зэргээс үүсэх аюул занал нь нийслэлийн оршин суугчдын амар тайван, аюулгүй орчинг зөрчиж байна. Төслийг хэрэгжүүлснээр эдгээр асуудлуудыг шийдвэрлэх том алхам болж чадна.



01

Монгол Улсын УИХ, Засгийн Газрын 2020 -2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт:

Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.

02

Улаанбаатар хотыг 2030 он хүртэлх мастер төлөвлөгөөнд:

Налайх хотыг үйлдвэр, суурьшлын бүс, мөн худалдаа логистикийн зангилаа хот болгох талаар тусгажээ.

03

Хуурай боомтын тухай засгийн газар хоорондын хэлэлцээрт:

Хуурай боомтыг байгуулж, ажиллуулахад мөрдөх үндсэн зарчмын дагуу “налайх олон улсын ачаа тээврийн парк” байгуулах төслийг хэрэгжүүлнэ. төсөл хамтран хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах сонгон шалгаруулалтын баримт бичгийг бэлтгэсэн.

04

“Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Нийслэлд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх журам”-ын дагуу зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг зарлан, төсөл хамтран хэрэгжүүлэх хувийн хэвшлийг сонгон шалгаруулах юм.




ТӨСӨЛ, ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ

GOALS

Нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудал

Улаанбаатар хотын өнөөгийн дэд бүтцийн тогтолцооны сөрөг үр дагавар бол хот дундуур явдаг төмөр замын тээвэр, олон тооны гарам, барилгын болон бөөний захууд, ачилт буулгалтын талбай, химийн, аюултай ачааны терминал, түгжрэл, ачааны машинуудын угаар, тоос, бохирдол зэргээс үүсэх аюул занал нь нийслэлийн оршин суугчдын амар тайван, аюулгүй орчинг зөрчиж байна. Төслийг хэрэгжүүлснээр эдгээр асуудлуудыг шийдвэрлэх том алхам болж чадна.



01

Монгол Улсын УИХ, Засгийн Газрын 2020 -2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт:

Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.

02

Улаанбаатар хотыг 2030 он хүртэлх мастер төлөвлөгөөнд:

Налайх хотыг үйлдвэр, суурьшлын бүс, мөн худалдаа логистикийн зангилаа хот болгох талаар тусгажээ.

03

Хуурай боомтын тухай засгийн газар хоорондын хэлэлцээрт:

Хуурай боомтыг байгуулж, ажиллуулахад мөрдөх үндсэн зарчмын дагуу “налайх олон улсын ачаа тээврийн парк” байгуулах төслийг хэрэгжүүлнэ. төсөл хамтран хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах сонгон шалгаруулалтын баримт бичгийг бэлтгэсэн.

04

“Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Нийслэлд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх журам”-ын дагуу зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг зарлан, төсөл хамтран хэрэгжүүлэх хувийн хэвшлийг сонгон шалгаруулах юм.